**МОНГОЛ УЛС**
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 07 өдөр Дугаар А/98 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.12 дахь хэсэг, Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаал, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Монгол орны хөрс, ургамал, геологи, уур амьсгалын өндрийн бүс бүслүүр, олон жилийн цэвдэг ул хөрсний тархац, цас их унасантай уялдан нийт нутгийн уруйн болон шар усны үер үүсэх нөхцөл байдалтай байна. Иймд аймгийн хэмжээнд шар усны үерийн ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:
Л.Бямбасүрэн - Онцгой байдлын газрын гамшгийн улсын хяналтын ахлах байцаагч, хошууч

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:
Ч.Цолмонзаяа - Онцгой байдлын газрын гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, ахлах ахлагч

Ажлын хэсгийн гишүүдэд:
Ч.Цогжаргал - Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн мэдээлэл үйлчилгээний албаны дарга
Ч.Мөнх-Эрдэнэ - Мал эмнэлгийн газрын мал амьтны эрүүл мэндийн албаны дарга
Г.Бямбасүрэн – Байгаль орчны аялал жуулчлалын газрын байгаль орчны улсын байцаагч
Б.Золжавхлан – Хөвсгөл нуур Эгийн голын сав газрын захиргааны гадаргын усны мэргэжилтэн
Сумдын Засаг дарга нар

2.Шар усны үерийн ерөнхий үнэлгээг хийж, урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж, үерийн гамшигт өртөх эрсдэл бүхий айл өрх, аж ахуй нэгжид мэдээлэл хүргэхийг Онцгой комиссын гишүүд, Шуурхай штабын дарга, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги болон сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар)-т зөвшөөрсүгэй.

6712010303

4.Шар усны эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх ажлыг шуурхай зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024